



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/644

Алтай хот

┌ Автомашины сэлбэг, сургуулийн ┐
нээлтэд зориулж хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын урсгал зардал хаагдсантай холбоотойгоор албан хэрэгцээнд ашиглаж буй автомашины сэлбэг, Алтай сумын Засаг даргын Тамгын газар, Бигэр сумын сургуулийн нээлтэд зориулж ухаалаг самбар, Сутай хайрхан уулын зураг авахад хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгөд шаардагдах 3496000 (Гурван сая дөрвөн зуун ерэн зургаан мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ